



ЭМЯ-ны дэргэдэх Мэдрэл судлалын
мэргэжлийн салбар зөвлөл
2020 оны 02 дугаар сарын 09-ны
өдрийн хурлаар батлав.

МЭДРЭЛ СУДЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОГЧДОД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Тусгай шаардлага	Ахлах зэрэг	Тэргүүлэх зэрэг	Зөвлөх зэрэг
1 Сүүлийн 5 жилийн хугацаанд ажиллаж буй байгууллагынхаа эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдрэлийн эмгэгтэй холбоотой мэдээлэл өгсөн, илтгэл тавьсан, сургалт зохион байгуулсан байх, үүнийг байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх.	≥3	-	-
2 Мэдрэл судлалын, анагаахын мэргэжлийн үндэсний буюу олон улсын сэтгүүлд мэдрэл судлалын судалгааны бүтээлийг туурвисан байх, үүний 1-р буюу хариуцлагатай зохиогч байх	≥1	≥2	≥10
3 Дотоод, гадаадын мэдрэл судлалын хуралд илтгэл тавьсан байх	≥1	≥3	≥10
4 Өөрийн байгууллагын өдөр тутмын практик үйл ажиллагаанд сурч эзэмшсэн оношилгоо, хяналт, эмчилгээний шинэ арга барилыг нэвтрүүлсэн байх (жишээ нь, тухайн байгууллагадаа шинээр хэт авиан оношилгоог нэвтрүүлсэн байх, эсвэл хяналт эмчилгээнд мэдрэлийн өвчний үнэлгээний аргыг шинээр ашиглаж нэвтрүүлсэн байх, дархлаа зүгшрүүлэх эмчилгээг ашиглаж нэвтрүүлсэн байх г.м.)	≥1	≥2	
5 Мэргэжлийн сэтгүүлд эмнэлзүйн ховор болон сонирхолтой тохиолдлын тухай өгүүлэл хэвлүүлсэн байх.	≥1	≥3	≥10
6 Монгол улсын хэмжээнд мөрдөгдөх мэдрэлийн эмгэгийн заавар, стандарт боловсруулсан буюу шинэчилсэн байх.	-	-	≥2
7 Тархины цахилгаан бичлэг, тархины судасны хэт авиан шинжилгээ, мэдрэл-булчингийн цахилгаан шинжилгээ зэрэг мэдрэлийн төрөлжсөн мэргэшүүлэх сургалтын аль нэгэнд хамрагдаж мэргэжлээ дээшлүүлсэн байх	-	≥1	≥2